

POLICY 2.0

СУРГАЛТАД ЗОРИУЛСАН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Та энэхүү 4 долоо хоногийн эрчимжүүлсэн аялалд нэгдсэнээр уйтгартай томъёо цээжлэхгүй. Харин макро эдийн засаг, төсвийн харилцааг Том зургаар нь харж, гишүүнийхээ ширээн дээр зоригтойгоор танилцуулж чадах мэргэжлийн **Бодлогын илтгэл (Мемо)** бичиж сурах болно.

Хөтөлбөрийн туршид болон төгссөний дараа ч таны өдөр тутмын ажилд хэрэг болох нэгдсэн **цахим санг** бид бүрдүүлсэн. Цахим санд дараах мэдээллүүд багтана. Үүнд:

- **Даалгаврын удирдамж:** Төгсөлтийн бодлогын илтгэл бичих загвар (Template) болон бие даалт гүйцэтгэх нарийвчилсан заавар.
- **Дата ба статистик:** Бодлогын дүн шинжилгээ хийхэд шаардлагатай дотоод, гадаадын албан ёсны тоо баримт, өгөгдлийн сангуудын жагсаалт.
- **Гүнзгийрүүлэн судлах нь:** Хичээл тус бүрийн төгсгөлд санал болгосон нэмэлт ном, судалгааны тайлан, видео контентууд нь сургалт дууссаны дараа ч таны мэдлэгээ бие даан тэлэх, хуулийн төсөл дээр ажиллахад зориулагдсан болно.

(Санамж: Дээрх цахим сангийн хандах эрхийг зөвхөн хөтөлбөрт бүртгүүлсэн оролцогчдын и-мэйл хаягаар өгнө).

МОДУЛЬ 1: ЭДИЙН ЗАСАГ

Ном, унших материал:

- Parkin, M. (2012). *Economics* (10th ed.). Pearson Education.
- Mankiw, N. G. (2016). *Macroeconomics* (9th ed.). Worth Publishers.
- Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах чиглэл
- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027–2028 оны төсвийн төсөөллийн тухай.
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль.

Хичээл 1: Эдийн засгийн онолын суурь

Гол ойлгох зүйл: Эдийн засаг гэдэг том машин хэрхэн ажилладаг, түүнийг хөдөлгөгч гол хүчнүүд болон хямрал, сэргэлтийн мөчлөг хэрхэн үүсдэг тухай суурь логикийг ойлгох.

Суралцах гол үр дүн: Хичээлийг дүүргэснээр оролцогчид улс орны эдийн засгийн эрүүл мэндийг хэмждэг ДНБ, инфляц зэрэг тоо баримтуудыг зөв уншиж, аливаа хямрал эсвэл өсөлтийг AD-AS (Нийт эрэлт, нийлүүлэлт) загвараар шинжлэх чадвартай болно.

Ярилцах сэдэв:

- Эдийн засгийн зорилго ба хэмжүүр (ДНБ, Инфляц, Ажилгүйдэл)
- Мөнгөний орчил урсгал (Өрх гэр, бизнес, төр, гадаад секторын харилцан хамаарал)
- Нийт эрэлт ба Нийлүүлэлтийн загвар (AD-AS загвар)
- Монголын эдийн засгийн түүхэн кэйс (Ковидын хямрал, хилийн гацалт, зудын давхар шок)

Бодох зүйл: Монголын эдийн засаг яагаад гадаад шоконд (хил хаагдах, дайн болох) ийм хэт эмзэг байдаг вэ? Бид үнийн өсөлтийг харахдаа энэ нь эрэлтээс үүдэлтэй юу, нийлүүлэлтээс үүдэлтэй юу гэдгийг ялгаж оношилж чаддаг уу?

Хичээл 2: Мөнгөний бодлого

Гол ойлгох зүйл: Төв банкнаас гаргаж буй бодлогын хүү болон мөнгөний нийлүүлэлтийн шийдвэрүүд нь иргэдийн халаас, зээлийн хүү болон долларын ханшид хэрхэн шууд нөлөөлдөг болохыг ойлгох.

Суралцах гол үр дүн: Инфляц болон валютын ханшийн савалгааны жинхэнэ шалтгааныг олж харж, Монголбанкны мэдээллүүдийг бодлогын түвшинд уншиж сурах.

Ярилцах сэдэв:

- Төв банкны зорилго ба Мөнгөний нийлүүлэлт
- Бодлогын хүү эдийн засагт нөлөөлөх механизм
- Инфляцын мөн чанар ба түүнийг хазаарлах аргууд
- Хөвөгч валютын ханш ба төлбөрийн тэнцэл.

Бодох зүйл: Сонгуулийн өмнө бэлэн мөнгө тараах нь богино хугацаанд гоё харагдах ч, дунд хугацаанд бидний халаасан дахь мөнгийг хэрхэн хулгайлдаг вэ? Төв банк яагаад долларын ханшийг хүчээр барьж болдоггүй вэ?

Хичээл 3: Сангийн бодлого

Гол ойлгох зүйл: Төр засаг татвар болон зардлаараа дамжуулан эдийн засгийг хэрхэн хөдөлгөдөг, төсвийн хууль дүрмүүд хэрхэн ажилладаг тухай.

Суралцах гол үр дүн: Төсвийн хүрээний мэдэгдэл, Төсвийн тухай хуулийн логикийг уншиж, төсвийн алдагдал, ил болон далд өрийн эрсдэлийг таньж чаддаг болох.

Ярилцах сэдэв:

- Татвар ба Зарцуулалтын бодлого (Тэлэх ба Хумих бодлого)
- Төсвийн хуулиуд ба Цагалбар (ТХМ, Төсвийн хууль, Иргэдийн төсөв)
- Алдагдал, Өр ба Шахан гаргах нөлөө (Crowding out)
- Төсвөөс гадуурх эрсдэл (Төрийн өмчит компаниуд)

Бодох зүйл: Улсын төсөв жил бүр тэлж байхад хувийн бизнесүүд зээл олдохгүй, татварын өрөө төлж чадахгүй байгаа шалтгаан юу вэ? Төсвийн дүрмийг өөрчлөх нь ямар хор уршигтай вэ?

Хичээл 4: Эдийн засгийн өсөлт

Гол ойлгох зүйл: Богино хугацааны хөөсрөлт биш, харин урт хугацаанд улс орон жинхэнэ утгаараа баяжих (баялаг бүтээх) суурь хүчин зүйлсийг ойлгох.

Суралцах гол үр дүн: Технологи, хүн капитал болон улс төр, эдийн засгийн институцийн эрүүл байдал нь хөгжлийн хурдыг хэрхэн тодорхойлдог болохыг дүн шинжлэх.

Ярилцах сэдэв:

- Урт хугацааны өсөлт ба Хөдөлмөрийн бүтээмж
- Газарзүй юу? Институц үү? (Acemoglu, Robinson нарын онол)
- Олборлогч (Extractive) ба Хүртээмжтэй (Inclusive) институцийн ялгаа
- Гүйцэн түрүүлэх өсөлт (Хөгжиж буй орнуудын боломж)

Бодох зүйл: Монгол улс байгалийн асар их баялагтай хэрнээ яагаад өндөр хөгжиж чадахгүй байна вэ? Бидний улс төр, хууль эрх зүйн орчин нь олборлогч шинжтэй байна уу, хүртээмжтэй шинжтэй байна уу?

МОДУЛЬ 2: ХӨГЖИЛ СУДЛАЛ

Ном, унших материал:

- Todaro, M. P., & Smith, S. C. (2015). *Economic development* (12th ed.). Pearson.
- Монгол Улс. (2020). Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль. <https://legalinfo.mn/mn/detail/15403>

Хичээл 1: Эдийн засгийн өсөлтөөс хөгжил рүү

Гол ойлгох зүйл: Эдийн засгийн тоон өсөлт (ДНБ) нь хүмүүсийн амьдралын чанар, хөгжилтэй үргэлж шууд утгаараа уялддаггүй бөгөөд хөгжил гэдэг нь зөвхөн орлого нэмэгдэх биш, хүмүүсийн сонголт хийх боломж тэлэхийг хэлнэ гэдгийг ойлгох.

Суралцах гол үр дүн: Ядуурал, тэгш бус байдлын жинхэнэ шалтгааныг шинжилж, зөвхөн тоо хөөсөн бодлогоос татгалзаж, хүн рүү чиглэсэн хөгжлийн бодлогыг ялгаж сурах.

Ярилцах сэдэв:

- Хөгжлийг хэмжих уламжлалт ба шинэ хандлага.
- Амартя Сэнийн "Чадавхын хандлага" (Эрх чөлөө ба Хөгжил).
- Хөгжлийн үндсэн гурван үнэ цэн (Амьд явах, Өөрийгөө хүндэтгэх, Сонголт хийх эрх чөлөө).
- Эмэгтэйчүүдийн оролцоо ба Хөгжлийн зорилтууд.
- Хөгжиж буй орнуудын нийтлэг 10 шинж чанар ба Монгол улсын өнөөгийн байдал.

Бодох зүйл: Уул уурхайгаас олсон орлогыг зөвхөн халамж хэлбэрээр тараах нь иргэдийн эрх чөлөөг тэлж (хөгжүүлж) байгаа хэрэг үү, эсвэл улс төрөөс хамааралтай болгож буй дөнгө үү?

Хичээл 2: Эдийн засгийн дотоод асуудал

Гол ойлгох зүйл: Нийгэм дэх баян ядуугийн хэт ялгаа болон боловсрол, эрүүл мэндийн салбарын хоцрогдол нь улс орны хөгжлийг хэрхэн гацаадаг болохыг ойлгох.

Суралцах гол үр дүн: Ядуурлыг хэмжих аргачлалуудыг мэдэж, хүн капитал (эрүүл мэнд, боловсрол)-д хийх хөрөнгө оруулалтын өгөөжийг бодлогын түвшинд шинжлэх.

Ярилцах сэдэв:

- Тэгш бус байдал, ядуурлын хэмжилт ба Нийгмийн сайн сайхан байдал.
- Ядуурал болон орлогын тэгш бус байдлыг шийдэх бодлогын хувилбарууд.
- Хүн капитал: Боловсрол ба эрүүл мэндийн эдийн засаг дахь үүрэг.
- Эрүүл мэндийн үзүүлэлт ба хөдөлмөрийн бүтээмж.

Бодох зүйл: Боловсролын тогтолцооны ялгаатай байдал нь ирээдүйн баян ядуугийн ялгааг хэрхэн гүнзгийрүүлж байна вэ?

Хичээл 3: Хөгжлийн уламжлалт ба орчин үеийн онолууд

Гол ойлгох зүйл: Хөгжиж буй орнууд яагаад "ядуурлын хавх"-нд ордог болон түүнийг сэтлэхийн тулд ямар бодлогын "түлхэц" хэрэгтэй байдаг тухай онолын үндэслэлийг судлах.

Суралцах гол үр дүн: Мега төслүүд болон аж үйлдвэржилтийн бодлогын цаадах эдийн засгийн шалтгааныг таньж, хамтын ажиллагааны бүтэлгүйтлийг шийдвэрлэх гарцыг харгах.

Ярилцах сэдэв:

- Хөгжлийн уламжлалт онолууд (Шугаман шатлал, Бүтцийн өөрчлөлт, Неоклассик).
- Орчин үеийн хандлага: Уялдуулалтын бэрхшээл (Coordination failure) ба Олон тэнцвэрийн бэрхшээл.
- Их түлхэлтийн онол (Big Push theory).
- Кремерийн О-цагирагийн онол ба Эдийн засгийн хөгжил өөрийгөө нээх тухай (Хаусман-Родрик-Веласко).

Бодох зүйл: Дэд бүтэц (зам, цахилгаан) байхгүйгээс хувийн хэвшил үйлдвэр барихгүй, үйлдвэр байхгүйгээс төр дэд бүтэц татахгүй гэсэн энэхүү гацаанаас төр хэрхэн "Их түлхэц" өгч гарах вэ?

Хичээл 4: Хөгжлийн бодлого боловсруулах нь: Зах зээл, төр болон иргэний нийгмийн оролцоо

Гол ойлгох зүйл: Хөгжлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн үүрэг, тэдгээрийн тэнцвэрийг хэрхэн зөв хангах талаарх ойлголт.

Суралцах гол үр дүн: Зах зээлийн бүтэлгүйтэл болон төрийн бүтэлгүйтлийн шалтгааныг ялгаж, бодлогын шинэчлэл яагаад гацдагийг институцийн түвшинд шинжлэх.

Ярилцах сэдэв:

- Төлөвлөлтийн үндэс ба Төр, Зах зээлийн бүтэлгүйтэл.
- Бодлогын шинэчлэлийн улс төрийн эдийн засаг: Бодлого яагаад гацдаг вэ?.
- Гурван тулгуурт хөгжил: Иргэний нийгэм ба ТББ-ын гүйцэтгэх үүрэг
- Сайн засаглал, Төвлөрлийг сааруулах ба Иргэдийн оролцоо.

Бодох зүйл: Шинэчлэл хийхэд хохирол хүлээх цөөнх нь яагаад үргэлж ялж, ашиг хүртэх олонх нь яагаад хохирч үлддэг вэ?

Хичээл 5: Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт

Гол ойлгох зүйл: Цаасан дээр бичигдсэн хөгжлийн төлөвлөгөө болон хуулийн орчин нь бодит амьдрал дээр төсөвтэйгөө хэрхэн уялдах ёстой тухай практик процесс.

Суралцах гол үр дүн: "Алсын хараа 2050" тэргүүтэй Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль, баримт бичгийн шатлал ба уялдаа.

Ярилцах сэдэв:

- Хөгжлийн бодлогын түүхэн замнал, алдаа ба Институцийн тогтворгүй байдал.
- Төлөвлөлтөд суурилсан төсөвлөлт ба Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хязгаарлалт
- Бодлого боловсруулах арга зүй: SMART зорилт, Нөлөөллийн үнэлгээ ба Бодлогын хувилбар.
- Хариуцлагын тогтолцоо: Хяналт-шинжилгээ ба "Think tank" байгууллагын үүрэг.

Бодох зүйл: Зорилтууд хэмжигдэхүйц (SMART) бус, уран сайхны халилтай байх нь Засгийн газрыг хариуцлагаас мултрах үүд хаалгыг хэрхэн нээдэг вэ?

Хичээл 6: Гадаадын санхүүжилт ба хөрөнгө оруулалт

Гол ойлгох зүйл: Гаднаас орж ирж буй мөнгө бүхэн ашигтай байдаггүйг таньж, зээл тусламжийн далд эрсдэл болон гадаадын хөрөнгө оруулалтын (FDI, Портфель) төрлүүдийн ялгааг ойлгох.

Суралцах гол үр дүн: Гадаад зээл, тусламжийн нөхцөлийг (Tied aid) уншиж, үнэлэх чадвартай болох.

Ярилцах сэдэв:

- Гадаад санхүүжилтийн хэрэгцээ
- Шууд хөрөнгө оруулалт (FDI) ба Портфелийн хөрөнгө оруулалт
- Гадаадын тусламж (ODA), Нөхцөлт тусламж (Tied Aid) ба Зээл олгогчийн зорилго.
- Шингээх чадавхи (Absorptive Capacity) ба ТББ-уудын үүрэг.

Бодох зүйл: Монгол улс байгалийн асар их баялагтай хэрнээ яагаад өндөр хөгжиж чадахгүй байна вэ? Бидний улс төр, хууль эрх зүйн орчин нь олборлогч шинжтэй байна уу, хүртээмжтэй шинжтэй байна уу?